



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/15/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Эрдэнэтуяа Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



"ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР" ОНВААТҮГ-
ЫН ДАРГА З.ЭРДЭНЗБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНВААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНВААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Дархан-Уул аймгийн ИХТ 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 37 тоот тогтоолоор 29,993.7 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, 178,090.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,343,200.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01-А/270 тоот Засаг даргын захирамжаар 2,137,763.1 мянган төгрөгөөр бусад үндсэн хөрөнгө, 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01-А/99 тоот захирамжаар 483,078.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,833,804.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 7,558,233.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын тайлант 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн гүйцэтгэл 152.12 хувийн биелэлттэй байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж томилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.БНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	97,341,320.81	3,777,991.15
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	874,322,480.23	789,318,994.28
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	971,663,801.04	793,096,985.43
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,753,380,548.04	20,649,213,677.61
1.2.2	Биет бус хөрөнгө	3,022,457,720.12	3,052,226,560.16
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,775,838,268.16	23,701,440,237.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,747,502,069.20	24,494,537,223.20
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр		177,198,935.69
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.00	177,198,935.69
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	21,022,748,703.85	28,580,981,981.47
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,275,246,634.65)	(4,263,643,693.96)
2.3.11	Эздийн өмчийн дүн	19,747,502,069.20	24,317,338,287.51
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,747,502,069.20	24,494,537,223.20

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,261,040,597.51	4,557,142,873.36
2	Борлуулалтын өртөг	-	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	3,261,040,597.51	4,557,142,873.36
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого		1,414,328,506.87
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,536,287,232.16	8,937,925,891.22
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал		0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(21,942,548.32)
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,275,246,634.65)	(2,988,397,059.31)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,275,246,634.65)	(2,988,397,059.31)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,275,246,634.65)	(2,988,397,059.31)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(1,275,246,634.65)	(2,988,397,059.31)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээн ий нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	42,496,917,900.00		-	-	42,496,917,900.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,275,246,634.65)	(1,275,246,634.65)
Өмчид гарсан өөрчлөлт	21,474,169,196.15				21,474,169,196.15
Залруулсан үлдэгдэл			-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-	-
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	21,022,748,703.85		-	(1,275,246,634.65)	19,747,502,069.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	21,022,748,703.85		-	(1,275,246,634.65)	19,747,502,069.20
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,988,397,059.31)	(2,988,397,059.31)
Өмчид гарсан өөрчлөлт	7,558,233,277.62		-		7,558,233,277.62
Бусад дэлгэрэнгүй орлого	-				-
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	28,580,981,981.47	-	-	(4,263,643,693.96)	24,317,338,287.51

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,143,597,097.51	5,875,549,348.23
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,143,597,097.51	5,875,549,348.23
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	2,965,897,864.51	4,160,280,000.00
	Бусад мөнгөн орлого	177,699,233.00	1,715,269,348.23
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,046,255,776.70	5,969,112,677.89
	Ажиллагчдад төлсөн	1,158,295,162.04	2,035,694,175.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	313,792,209.47	539,669,104.79
	Бараа материал худалдан авахад төлсөн		-
	Ашиглалтын зардалд төлсөн	200,669,679.10	429,947,703.95
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	773,982,848.49	596,959,192.92
	Хүүний төлбөрт төлсөн		-
	Татварын байгууллагад төлсөн		-
	Даатгалын төлбөрт төлсөн		2,440,000.00
	Бусад мөнгөн зарлага	599,515,877.60	2,364,402,501.23
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	97,341,320.81	(93,563,329.66)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Төлсөн ногдол ашиг		-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	97,341,320.81	(93,563,329.66)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		97,341,320.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,341,320.81	3,777,991.15

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
Нийт орлого	м/төг	3,261,040.50	5,875,549.30	5,971,471.30	95,922.00	101.63%
Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	3,261,040.50	5,875,549.30	5,971,471.30	95,922.00	101.63%
Нийт зардал	м/төг	4,536,287.20	5,875,549.30	8,959,868.30	3,084,319.60	152.12%
Үүнээс:						
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	4,536,287.20	5,875,549.30	8,959,868.30	3,084,319.60	152.12%
в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
Цэвэр ашиг, алдагдал	м/төг	1,275,246.70	0.00	(2,988,397.00)		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 106,696.7 мянган төгрөгийн алдаа зөрчил¹ илэрснээс 284.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23,197.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 83,215.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

- Нарс гацуур модыг зарлагдахдаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд бүртгэж хий өсгөсөн. Үндсэн хөрөнгөөр орлого авахдаа үнэ төлбөргүй орлого авч эзэдийн өмчийг хий өсгөж 70,600.0 мянган төгрөгөөр бүртгэсэн,
- Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 6,041.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд шуудан холбооны зардлыг 6,286.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

- Тээвэр шатахууны зардлыг түлш халаалтын зардалд 287.1 мянган төгрөгөөр тайлагнасан зэргийг аудитын явцад тус тус залруулав.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тус байгууллага нь ажиллагсдад олгох илүү цагийн нэмэгдэл хөлс тооцооны алдааны улмаас 17 ажилтанд нийт 284.3 мянган төгрөгийн цалин илүү цаг олгосон байна. Энэ нь *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх заалтад “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, Хөдөлмөрийн тухай хуулийн 109.1 дэх заалтад “Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”* гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж²

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой

Илрүүлэлт:

- Сэлбэг бараа материалын худалдан авалтын нэхэмжлэх 21,950.1 мянган төгрөгийг цахимаар баталгаажуулаагүйгээс баримтаар нотлогдох зардлаас хасагдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.
Өгсөн зөвлөмж: *Анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.*

Илрүүлэлт:

- Татварын орлогод төвлөрүүлэх хогны орлогыг дутуу төвлөрүүлсэн дүн 1,247.1 мянган төгрөгийг татварт өглөг үүсгээгүй байна. Энэ нь “Нягтланг бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20-р зүйлийн 20.2.5-т *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 3 дугаар зүйлийн 3.1.1-д *“Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь”* гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг”, 6 дугаар зүйлийн 6.1-д *“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.”* гэсэн заалттай тус тус нийцэхгүй

² 20.5.Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

байна. Өгсөн зөвлөмж: ажил гүйлгээг гарсан тухай бүр аккруэл сууриар бүртгэж тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нарс гацуур модыг зарлагдахдаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд бүртгэж хий өсгөсөн. Үндсэн хөрөнгөөөр орлого авахдаа үнэ төлбүргүй орлого авч эзэдийн өмчийг хий өсгөж бүртгэснийг залруулав.	1	70,600.0			1	70,600.0	1	70,600.0				
Үр дүнгийн тайланд цалингийн зардалыг дутуу тайлагнасан	1	6,041.7	1	6,041.7			1	6,041.7				
Үр дүнгийн тайланд шуудан холбооны зардалыг илүү тайлагнасан	1	6,286.4			1	6,286.4	1	6,286.4				
Тээвэр шатахууны зардлыг түлш халаалтын зардалд тайлагнасан	1	287.1			1	287.1	1	287.1				
Дүн	4	83,215.2	1	6,041.7	3	77,173.5	4	83,215.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Сэлбэг бараа материалын худалдан авалтын нэхэмжлэхийг цахимаар баталгаажуулаагүйгээс баримтаар нотлогдох зардлаар хасагдаагүй байна.	1	21,950.1					1	21,950.1				
Татварын орлогод төвлөрүүлэх хогны орлогыг дутуу төвлөрүүлсэн дүнг татварт өглөг үүсгээгүй.	1	1,247.1					1	1,247.1				
Тус газрын 20 ажилтанд илүү цагийн нэмэгдлийг 284.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн илүү олгосон.	1	284.3		284.3								
Дүн	3	23,481.5	1	284.3			1	23,197.2			-	-